



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

**Эмнэлгийн тусламж, үйлчилгээг
зохицуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Нийслэлийн Засаг даргын 2017 оны Төлөвлөгөө батлах тухай А/577 дугаар захирамж, Эрүүл мэндийн сайдын 2014 оны Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай 358, Эрүүл мэндийн сайдын 2017 оны Төлөвлөгөө батлах тухай А/346 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага насны хүүхдийн амьсгалын замын өвчлөл нэмэгдэж, хүндрэл ихэсч байгаатай холбогдуулан Өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ажлын өдрүүдэд 17.30-19.00, Бямба гаригт 10.00-16.00 цагийн хооронд, дүүргийн Эрүүл мэндийн төвийн хүүхдийн кабинетыг ажлын өдрүүдэд 08.30-22.00, Ням гаригт 10-16 цаг хүртэл уртасгасан цагаар тус тус ажиллуулсугай.

2. Хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн тоо эрс ихэсч, орны ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлдэг тус дүүргийн 4-8 дугаар хорооны насанд хүрэгсдийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвд шилжүүлсүгэй.

3. Хан-Уул дүүргийн 4-8 дугаар хорооны насанд хүрэгсдийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй зохион байгуулж ажиллахыг Хан-уул дүүргийн Эрүүл мэндийн төв /Э.Бодьцэцэг/, тусламж, үйлчилгээний хүрээ өөрчлөгдөж байгаатай холбогдуулан яаралтай түргэн тусламжийн дуудлага өгсөн тус хороодын насанд хүрэгчдийг цаг алдалгүй Хан-уул дүүргийн Эрүүл мэндийн төвд түргэн ажиллахыг Нийслэлийн түргэн тусламжийн төв /Ц.Пүрэвдаш/-д тус тус даалгасугай.

4. Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрх, Тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгох нь:

4.1 Өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүд гэрийн эргэлтийн үйл ажиллагааг өргөжүүлж, 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийг гэрээр үзэж, зөвлөгөө өгч ажиллах,

4.2 Хүүхдийн өвчний эрэмбэлэн ангилалтыг сайжруулж, тусламж үйлчилгээг цаг алдалгүй, оновчтой үзүүлэх,

4.3 Ажлын цаг ашиглалт, уртасгасан цагийн горимыг хатуу чанд баримтлан, хэрэгжилтэнд хяналт тавих,

1150500004

4.4 Дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвөөс өрх, тосгоны эмч, сувилагч нарыг мэргэжил, арга зүйгээр ханган, үйл ажиллагаагаа уялдуулан, хамтран ажиллах.

4.5. Хүлээн авах тасгийн тусламж, үйлчилгээнд шуурхай байдлыг хангах, хүний нөөцийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгч нарт ээлтэй орчин бүрдүүлэх, хүлээгдэл чирэгдэлгүй үйлчлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах,

4.6. Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг сайжруулж, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж, өрөө тасалгааны ариун цэвэр, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийх,

4.7. Байгууллагын дотоодын дэмжлэгт хяналтыг тогтмол зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах.

4.8. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, томуугийн үед гэрээр үзүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг эцэг эх, асран хамгаалагчдад өргөн хүрээтэй хүргэн, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах,

5. Дүүргийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн кабинет, салбар амбулатори, нэгдсэн эмнэлэг, өрх, тосгоны эрүүл мэндийн төвд уртасгасан цагаар ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн илүү цагийн тооцоог гарган, Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед илүү цагийн хөлс олгох зардлаас тооцож, цалинг олгохыг дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн дарга нарт тус тус даалгасугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/, Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс /О.Энхзаяа/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР